



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/ЗНЧ

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, Монгол улсын Сангийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” 188 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1.3, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/561 дүгээр захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны тухай хөтөлбөр”-ийн 2.1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнги хотод 2024 оны 05 дугаар сарын 22-ноос 05 дугаар сарын 26-ны өдрүүдэд зохион байгуулагдах Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбооны (NEAR) хуралд төлөөлөгчдийг оролцуулж, замын зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 6,493,600 (зургаан сая дөрвөн зуун ерэн гурав мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

0224 11 0710

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 43/2024 дугаар захирамжийн хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГААС БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ГЁНГИ
ХОТОД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ЗҮҮН ХОЙД АЗИЙН НУТГИЙН ЗАХИРГААДЫН
ХОЛБООНЫ ХУРАЛД ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Чиглэл	Зардал	Нийт зардал
1.	Улаанбаатар-Инчон-Улаанбаатар	1,041,800x2хүн 2 талдаа	2,083,600 төгрөг
2.	Буудал	150(s)x 3хоног 2 хүн	900 (s) буюу 3,150,000төгрөг
3.	Зам хоног (хоол), хот доторх тээвэр	60(s)x 3хоног 2 хүн	360 (s) буюу 1,260,000төгрөг
Нийт			6,493,600

Долларын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн ханшаар тооцов.
1 доллар=3500 төгрөг

-oOo-